



Oie

eofmd
europaen commissie voor de
control of food and mouth disease



ШҮЛХИЙ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ ШАТАЛСАН АРГА ХЭМЖЭЭ


*Зарчим, үе шат тус бүрийн тайлбар, стандартууд**

Улаанбаатар
2011 он

ШҮЛХИЙ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ ШАТАЛСАН АРГА ХЭМЖЭЭ

(ШӨТШАХ)

Зарчим, үе шат тус бүрийн тайлбар, стандартууд*



* Лабораторийн баталгаажуулалт болон Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагаас гишүүн орнуудынхаа Мал эмнэлгийн албадын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн хөтөлбөр зэрэг шаардлагатай баримт бичгүүдийг хавсаргав.

АГУУЛГА

I. ШӨТШАХ-НИЙ ЗАРЧИМ БА ХЭРЭГЛЭЭ	3
А. ШАХ-ний зарчим	4
Б. ШАХ-ний үе шат тус бүрийн онцлог	4
В. ШАХ-ний хэрэгжилтийг үнэлэх аргачлал	5
Г. ШАХ ба бүсийн хэмжээнд хэрэгжиж буй ижил төст хөтөлбөрүүдийн уялдаа	8
II. ШАХ БА ОРОЛЦОГЧ ТАЛУУД	9
III. ШАХ БА МЭДЭЭЛЭЛ	9
IV. ШАХ-НИЙ ҮЕ ШАТ ТУС БҮРИЙН ТАЙЛБАР, ТЭДГЭЭРТ ТАВИГДАХ МИНИМУМ СТАНДАРТ ШААРДЛАГА	11

I. ШӨТШАХ-НИЙ ЗАРЧИМ БА ХЭРЭГЛЭЭ

Шүлхий өвчний орогномол халдварын улмаас улс орнуудад учрах хохирлыг бууруулах, үүсгэгч вирусийн тархалтыг хумих зорилгоор Нэгдсэн үндэсний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ)-аас эрхлэн Шүлхий өвчинтэй тэмцэх шаталсан арга хэмжээ (**ШӨТШАХ**)-ний энэхүү баримт бичгийг боловсруулав. Үндэсний (зарим бүсийн) хэмжээнд шүлхий өвчинтэй тэмцэх хөтөлбөрийг загварчлахад тулгуур болдог уг баримт бичгийг харилцан зөвшилцсөний эцэст ХХААБ/Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллага (ДАЭМБ)-аас нэгдсэн байдлаар мөрддөг боллоо. **ХХААБ/ДАЭМБ-аас баримтлах Дэлхийн хэмжээнд шүлхий өвчинтэй тэмцэх стратегийн гол** ноён нурууг ШӨТШАХ-нд түшиглэн босгохоор төлөвлөж байна. Шүлхий өвчнөөр тайван байдаг орнуудад өвчний халдвар орж ирлээ гэхэд ШАХ хэрэгжүүлнэ гэлгүйгээр түүнийг шууд устгах арга хэрэглэн шүлхийгүй гэсэн албан ёсны статусаа аль болох богино хугацаанд сэргээлгэхээр ДАЭМБ-д өргөдөл гаргах боломжтой. ШАХ-ний сүүлийн шатанд баримтлах Шүлхий өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг ДАЭМБ-аас «баталж» байх боломжийг судалж байгаа ба түүнийг тус байгууллагын мэргэжлийн зөвлөл болон Гишүүн орнуудын төлөөлөгчдийн чуулганаас дэмжих хандлагатай байна.

ШӨТШАХ нь цогц үйл ажиллагаа бүхий үе шатуудаас бүрддэг (Зураг 1). Үүнийг хэрэгжүүлснээр тухайн улсын шүлхий өвчний эсрэг авч буй арга хэмжээний түвшин нь алхам алхмаар дээшлэн, шүлхий өвчинтэй тэмцэх дархлаажуулалтын үндэсний хөтөлбөр (**3-р үе шатны** бэлтгэл үе) болон шүлхийгүй-вакцин хэрэглэдэг/шүлхийгүй-вакцин хэрэглэдэггүй статус (**4, 5-р үе шатны** төгсгөл)-аа ДАЭМБ-аар батлуулах хүсэлт нь амжилтанд хүрч, улмаар үр дүнгээ тогтвортой хадгалах чадавхтай болох ёстой.



А. ШАХ-ний зарчим

ШАХ-ний аргачлал нь дараах зарчимд тулгуурлана:

- Шүлхийн вирусийн эргэлтийг идэвхтэй тандах, эпидемиологийн зүй тогтлыг ойлгох нь тэмцэх арга хэмжээний бүхий л үе шатны үндсэн суурь болдог. Энэ чиглэлийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон мэдээлэл үндэсний болоод бүсийн хэмжээний ач холбогдолтой. Тухайн улсын шүлхий өвчинтэй тэмцэх тогтолцооны үр дүнд хяналт тавих (шалгуур үзүүлэлтийн дагуу) ажлыг ШАХ-ний дээд үе шатуудад зохион байгуулна.
- ШАХ-ний үе шат тус бүрт хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь вирусийн эргэлтийг намжаах, өвчний эрсдэлийг бууруулахад чиглэгдэнэ.
- Хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр нөлөө нь үе шат бүртээ тодорхой хэмжигдэхүүнээр үнэлэх бусад орнуудынхтай харьцуулах боломжтой байхаас гадна шинэ мэдээ мэдэгдэхүүн бий болгосон, үндэсний төдийгүй олон улсын хэмжээнд ач холбогдолтой байна.
- Шүлхийтэй тэмцэх арга хэмжээг мал аж ахуй эрхлэх онцлогоос гадна энэ өвчинтэй тэмцэхэд гарч болох болох эсвэл вирусын эргэлтээс учирч болох үр дагавар хамгийн их байх эрсдэлт хүчин зүйлд чиглүүлэх замаар өвчинтэй тэмцэх арга хэмжээний нөөцийн ашиглалтыг илүү оновчтой болгоно.

Б. ШАХ-ний үе шат тус бүрийн онцлог

ШАХ нь шууд хэрэглэх бэлэн жор биш, харин үр дүнд хүргэх аргачлал юм. Шийдвэрлэх гол үр дүнд хүргэх хамгийн зөв шийдэл улс орнуудад өөр өөр байна. Түүнчлэн улс орнуудын эн тэргүүнд тавьж буй асуудлууд харилцан адилгүй байж болох учраас ШАХ-г уян хатан байхаар бодож боловсруулсан. Улс орнууд ШАХ-ын эхэн үедөвчинтэй тэмцэх арга хэмжээгээ мал аж ахуйн тодорхой салбарт хэрэгжүүлэн ШАХ-г хэр зэрэг богино хугацаанд аль төвшинд хүргэхээ өөрийнхөөрөө шийдэх боломжтой. **Нэгдүгээр шатыг** хэрэгжүүлсэн орны логик зорилго нь мэдээж **2-р шатанд** дэвших явдал юм.

Гэвч **2** эсвэл **3-р үе шатнаас** цааш ахихгүй гэж шийдэж болно. Учир нь, энэ хоёр үе шатанд шүлхийн эсрэг арга хэмжээг тодорхой төвшинд тогтвортой хэрэгжүүлж болдог.

Дөрөвдүгээр үе шат өөд тэмүүлэх нь шүлхийгүй-вакцин хэрэглэдэг эсвэл шүлхийгүй-вакцин хэрэглэдэггүй гэсэн статусыг бүх нутаг дэвсгэрийн хэмжээнд юм уу хэсэгчлэн тогтоохоор зорьж байгааг илтгэнэ. Харин **5-р үе шатанд** тухайн улс шүлхийгүй-вакцин хэрэглэдэггүй гэсэн статус авалгүйгээр вакцинжуулалтын арга хэмжээгээ үргэлжлүүлж болно.

В. ШАХ-ний хэрэгжилтийг үнэлэх аргачлал

ШАХ хэрэгжүүлж буй улс орон аль шатанд багтаж байгаагаа дэлхийн хэмжээнд нэгэн жигд мөрддөг чанарын стандарт болох нотолгоонд тулгуурласан, ил тод үнэлгээгээр жил бүр тогтоож байх хэрэгтэй. Нөгөө талаас үнэлгээнд хамрагдаж буй улс ШАХ-ний шийдвэрлэх үр дүнд чиглэсэн ямар үйл ажиллагаа явуулсан, ямар амжилт гаргасан тухайгаа нотлох чадвартай байх ёстой.

Үнэлгээ хийж үе шатыг тодорхойлох ажлыг тухайн улсын хүрээнд хийдэг хэдий ч нэг бүсэд оршдог бусад орнуудтай ижил хугацаанд хийх, ялангуяа бүсийн жил тутмын хурлаар хамтад нь хэлэлцэх нь зүйтэй. Улс орнуудын үйл ажиллагааг бүсийн хэмжээнд харьцуулан үнэлэх нь ил тод байдал, хариуцлагыг өндөржүүлж, бүсийн хэмжээнд тулгарч буй нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд чухал алхам болохоос гадна мэдээлэл солилцох, урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөхөд (вакцины сонголт, стандарт, вакцинжуулалтын протоколыг уялдуулах гэх мэт) нь дэмжлэг үзүүлнэ. Ийм үнэлгээ хийх нь гарсан дэвшлийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, улмаар сайжруулах шаардлагатай чиглэлээр үзүүлэх туслалцааг тодорхойлох боломж олгоно. Албан ёсны үнэлгээ хийхэд ХХААБ, ДАЭМБ-ын хамтарсан Хил даван халдварлах өвчнүүдтэй тэмцэх дэлхий нийтийн тулгуур зарчим (**ХДХӨТДНТЗ**)-ыг баримтална. ХДХӨТДНТЗ-ын Удирдах хороо болон Зохион байгуулалтын Хороонд ажлаа тайлагнадаг Дэлхийн Шүлхий өвчинтэй тэмцэх ажлын хэсэг (**ШӨТАХ**) үнэлгээний гол бие бүрэлдүүнээр ажиллана. ШӨТАХ-ийн өдөр тутмын үйл ажиллагаанд Ром хотноо байрлах ХХААБ/ДАЭМБ-ын хамтарсан Хэрэг эрхлэх газар дэмжлэг үзүүлнэ.

Нэгээс 4-р үе шатанд явж байгаа орнууд ШӨТШАХ-г хэрхэн хэрэгжүүлж байгаа тухайгаа жил тутам мэдээлж байх ёстой. ШӨТШАХ-г хэрэгжүүлж буй орнуудаас нэг стандартаар мэдээлэл авах зорилгоор ШӨТАХ-ээс загвар асуумж гаргана.

ШӨТШАХ-ний техникийн үнэлгээг ШӨТАХ юм уу Хэрэг эрхлэх газарт харъяалагддаг, эсвэл ШӨТАХ-ээс томилогдож удирдлаган дор нь ажиллах мэргэжилтэн гүйцэтгэнэ.



Тухайн улсын хүсэлтийн дагуу, эсвэл өгсөн мэдээллийнх нь бодитой эсэхийг магадлах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд мэргэжилтнүүд тухайн улсад очиж танилцана. ШӨТАХ-ийн мэргэжилтнүүд ШӨТШАХ-ний холбогдолтой бүсийн хурал чуулганд оролцож, дэлхий нийтийн хэмжээнд харилцан уялдсан, тэнцвэртэй үйл ажиллагаа явагдаж буй эсэхийг хянаж болно. Шүлхийн мэргэжилтнийг ХХААБ болон ДАЭМБ-аар хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтнүүдээс сонгоно.

Мэргэжилтнүүдийн бичсэн тайлан болон зөвлөмжийг ШӨТАХ-т танилцуулна. ШӨТАХ нь ШӨТШАХ-ний асуудлаар тухайн улстай харилцах үүрэгтэй. ШӨТАХ нь Дэлхийн хэмжээнд шүлхий өвчинтэй тэмцэх стратеги үндэсний, бүсийн, дэлхийн хэмжээнд хэрхэн хэрэгжиж байгаа талаар ХДХӨТДНТЗ-ын Дэлхийн Удирдах Хороо болон Зохион байгуулалтын Хороонд жил бүр тайлагнана. Тус тайланд аль орныг ШАХ-ний ямар үе шатанд хамааруулах саналаа илэрхийлнэ. Үүний дараа үе шатыг хэвээр үлдээх, бууруулах, эсвэл дэвшүүлэх талаар ХДХӨТДНТЗ-ын Удирдах Хорооны шийдвэр гарч холбогдох улсад танилцуулна. Ийнхүү тухайн улсын ШАХ-ний тохирох үе шатыг ХДХӨТДНТЗ баталгаажуулна.

ШӨТАХ нь Бүсийн ХДХӨТДНТЗ-ын Удирдах Хороодтой холбоотой ажиллана. Бүсийн ХДХӨТДНТЗ-ын Удирдах Хороод нь зөвлөгөө өгөх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх замаар Дэлхийн хэмжээнд шүлхий өвчинтэй тэмцэх стратегийг дэмжихэд чухал үүрэгтэй учир ШАХ-ний үйл явцад идэвхтэй оролцоно. ХДХӨТДНТЗ-ын Бүсийн Удирдах Хороодын хурлын хэлэлцэх асуудалд тухайн бүсийн ШӨТШАХ-ний явцын талаарх мэдээлэл орж байх болно.

Тухайн улс ШАХ-ний **3-р үе шатанд** орсон нь ХДХӨТДНТЗ-аар баталгаажин, улмаар тэжээвэр мал сүргээ шүлхийн вирүсийн халдваргүй болгох зорилт тавьж **4 ба түүнээс дээш үе шатанд дэвшихээр шийдсэн** тохиолдолд ДАЭМБ-д хандан Шүлхий өвчнийг устгах үндэсний хөтөлбөрөө баталгаажуулах хүсэлт гаргаж болно. Баталгаажуулах журмыг ДАЭМБ-аас авч болно.

Дөрвөөс 5-р үе шатанд дэвших, улмаар ШАХ-ийг **гүйцээн хэрэгжүүлэхдээ** ДАЭМБ-ын шүлхийгүй-вакцин хэрэглэдэг, шүлхийгүй-вакцин хэрэглэдэггүй статусыг тогтоох одоогийн журмыг мөрдөнө.

Тухайн улсын янз бүрийн хэсэгт шүлхийтэй тэмцэх арга хэмжээний төвшин өөр өөр байж болно. Энэ талаар ШАХ-нд «бүсчлэх» зарчмыг тусгасан бөгөөд нэг улсын дотор газар зүйн хувьд ялгаатай «бүсүүд» ШАХ-ний өөр өөр үе шатыг хэрэгжүүлж болохоор заажээ.

Учир нь, ШАХ-ний эхний үе шатанд шүлхийн эрсдэлийн ерөнхий ойлголт бий болгох, тэмцэх арга хэмжээгмалын төрлөөр зохион байгуулахад анхаардаг бол шүлхийтэй тэмцэх ажлыг илүү өндөр төвшинд хэрэгжүүлдэг бүс байгуулах асуудлыг 3 ба түүнээс дээш үе шатандавч үзнэ. Гэвч бүсчлэлийгзарим онцгой нөхцөлд (жишээлбэл, тухайн улсын зөвхөн тодорхой нэг нутаг дэвсгэрийн саалийн үхрийг тэмцэх арга хэмжээндхамруулжбайгаа тохиолдолд) **2-р үе шатанд** хэрэгжүүлж болно. Тухайн улс газар зүйн тодорхой нутаг дэвсгэрийг ШАХ-ний «бүс» болгох шийдвэр гаргасан тохиолдолд үндэслэлээ нотолгоонд суурилж тайлбарлах ёстой. Бүсчлэх бүтэц нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн онцлогийг (үндэсний болон бүсийн/олон улсын мал амьтны шилжилт хөдөлгөөн гэх мэт) харгалзан, ДАЭМБ-ын Хуурай газрын амьтны эрүүл мэндийн кодын холбогдох заалттай нийцсэн байх ёстой.

Тухайн улс/бүсийн мал сүрэгт шүлхийн вирусн байнгын эргэлт үгүй болсныг нотолсноор ШАХ-ын **4-р үе шатанд** шилждэг болохоор нэгэнт **4-р үе шатанд** хүрсэн тэрхүү байдлаа худалдааны таатай нөхцл болгон сайтар ашиглах хэрэгтэй. Гэвч **3-р үе шат** болон **4-р үе шатны** эхэн үе нь ДАЭМБ-аас албан ёсоор баталгаажуулдаг шүлхий өвчингүй гэсэн аль ч статустай холбоогүй гэдгийг анхаарах нь зүйтэй. Гэсэн хэдий ч ШАХ-ний үнэлгээг ил тод, өндөр стандартын дагуу хийдэг болохоор тухайн улсын Шүлхий өвчнийг устгах үндэсний хөтөлбөр ДАЭМБ-аар баталгаажсан тохиолдолд худалдааны гэрээ хэлцэл байгуулахад нь ач тустай байх болно.



Г. ШАХ ба бүсийн хэмжээнд хэрэгжиж буй ижил төст хөтөлбөрүүдийн уялдаа

Зарим бүс нутагт шүлхий өвчинтэй тэмцэх арга хэмжээг бүсийн хэмжээнд дэмжих, уялдуулах зорилго бүхий зохион байгуулалттай бүтэц, хөтөлбөрүүд бий. Европын Холбооны Шүлхий өвчинтэй тэмцэх хөтөлбөр, түүнтэй хамтран ажилладаг Европын орнуудын хамтын ажиллагааны хөтөлбөр болон Баруун Евразийн шүлхий өвчинтэй тэмцэх хөтөлбөр, мөн Зүүн Өмнөд Ази, Хятад улсад 2020 он хүртэл шүлхий өвчинтэй тэмцэх хөтөлбөр, Өмнөд Америкийн шүлхий өвчнийг устгах төлөвлөгөөг гол жишээ болгон дурьдаж болох юм. Ийм хөтөлбөр хэрэгжүүлдэггүй бүсэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий ШАХ нь ХДХӨТДНТЗ-ын Удирдах Хороодод харъяалагддаг бүсийн хэмжээний бусад хөтөлбөрүүдийн нэгэн адил холбогдох нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар тайлагнана. Тэмцэх арга хэмжээг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулах, чухал нөлөө бүхий эгзэгтэй асуудлууд, эрсдэлийн талаарх ойлголтыг дээшлүүлэх гэх мэтчилэн ШАХ-ийнхтэй нэгэн ижил утга санаа бүхий агуулга, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд одоо хэрэгжиж буй хөтөлбөрүүдэд ч бий.

II. ШАХ БА ОРОЛЦОГЧ ТАЛУУД


Шүлхий өвчинтэй тэмцэх арга хэмжээний амжилтыг малчид, мал бүхий иргэд болон үйлдвэрлэгчээс зах зээл хүртэлх бүхий л шат дамжлагад оролцогсдын дэмжлэг үгүйгээр төсөөлөх аргагүй юм. Иймд тэдний тогтвортой дэмжлэгийг авахын тулд ихээхэн хүчин чармайлт гаргаж ажиллах хэрэгтэй. Ялангуяа ШӨТШАХ-ний дээд үе шатуудад ямар үр дүнд хүрсэн, тэр нь цаашдаа хэр тогтвортой үргэлжлэх боломжтой байгааг үнэлэхэд Шүлхий өвчинтэй тэмцэх үндэсний төлөвлөгөө оролцогч талуудын дэмжлэг авсан эсэх нотолгоо шаардагдана.

III. ШАХ БА МЭДЭЭЛЭЛ

ШӨТШАХ-ний хүрээнд мэдээлэл цуглуулах ажил нь ХХААБ ба ДАЭМБ-ын нууцлалын журмын дагуу явагдана.

ШАХ-нд оролцож буй улсын өгч байгаа мэдээллийг ХХААБ, ДАЭМБ болон тэдний мэргэжилтнүүдашиглан ШӨТШАХ-ний аль үе шатыг хэрэгжүүлж байгааг нь тодорхойлоход ашигладаг. Энэхүү үнэлгээний үр дүн нийтийн хүртээл болох бөгөөд ШӨТАХ-ийн вебсайтад нийтлэгдэнэ. Гэвч гол мэдээллийг тухайн орны зөвшөөрөлгүйгээр чөлөөтэй цацахгүй.





Зураг 1. Шүлхий өвчинтэй тэмцэх шаталсан арга хэмжээний үе шат

(1) Энэ үе шатанд хүрсэн улс шүлхий өвчнийг устгах стратеги зорилт тавьсан тухайгаа илтгэсэн Шүлхий өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрөө батлуулахаар ДАЭМБ-д хандаж болно (Хуудас 4).

IV. ШАХ-НИЙ ҮЕ ШАТ ТУС БҮРИЙН ТАЙЛБАР, ТЭДГЭЭРТ ТАВИГДАХ НААД ЗАХЫН СТАНДАРТ ШААРДЛАГА¹

Зураг 1-т нэгтгэн үзүүлсэн ШАХ-ний мэдээллийг доор дэлгэрэнгүй тайлбарлав. ‘Чиглэл’ гэдэг нь тухайн үе шатны ерөнхий зорилт, зорилго бөгөөд энэхүү зорилгод хүрэхэд шаардагдах ‘гол үр дүнгүүд’-ийг агуулна. Тухайн улс ШАХ-ний аль түвшинд хир зэрэг түргэн хүрэхээ өөрөө шийдэх эрхтэй. Иймд ‘Чиглэл’ хэсэгт тухайн улсыг дараагийн түвшинд шилжих эсэхийг заах шаардлагагүй юм.

Үе шат ахихын тулд тухайн улс өмнөх үе шатныхаа бүхий л үр дүнд хүрсэн байхаас гадна дэвших гэж буй үе шатныхаа наад захын шаардлагыг хангасан байх ёстой. Нэгэн үе шатыг дуусгавар болгох нь дараагийн үе шатанд шилжихэд бэлэн болсныг илтгэх ‘шалгуур’ үр дүнг биелүүлсэн эсэхээс хамаарна. Үе шат тус бүрийн шалгуур үзүүлэлтийг зураг 1-т үзүүлэв.

ШАХ-ний аргачлал нь шууд хуулбарлан хэрэглэх жор биш юм. Ялангуяа доод үе шатуудад шаардлагатай үйл ажиллагаануудыг хослуулан хэрэгжүүлж болно. Гол үр дүнг ил тод үнэлэхэд дөхөм үзүүлэх зорилгоор ‘нийтлэг үйл ажиллагаа’-г ‘чанарын шалгуур үзүүлэлт’-ийн хамтаар дор жагсаав. Тухайн үе шатыг бүрэн дуусгаж дараагийн үе шатанд дэвшихийн тулд бүх гол үр дүнд хүрсэн байх нь чухал.

¹ ШАХ-ний үе шатны тайлбарыг шинэчилсэн тухай: 2010 оны 10 дугаар сарын 4-6-ны өдрүүдэд Шүлхий өвчний Дэлхийн Лавлагаа Лаборатори дээр Зөвлөх бүлгийн уулзалт болж ШАХ-ний үе шатны тодорхойлолт, тавигдах шаардлагуудыг эргэж нягталсан юм. Уулзалтын үр дүнд өмнө нь «Шүлхийгүй-вакцин хэрэглэдэг» гэсэн тодорхойлолттой байсан 4-р үе шатыг «Шүлхийгүй-вакцин хэрэглэдэг статусын төлөө ажиллаж байгаа» гэж өөрчлөн томъёолох нь зүйтэй гэж үзэн, «Шүлхийгүй-вакцин хэрэглэдэг» болохыг албан ёсоор баталгаажуулах ажлыг 4, 5-р үе шатанд гүйцэтгэхээр болжээ. Тавдугаар үе шатанд тухайн улс «Шүлхийгүй-вакцин хэрэглэдэг» гэсэн албан ёсны статусаа хадгалах бөгөөд цаашид вакцинжуулалтын арга хэмжээгээ зогсоож, «Шүлхийгүй-вакцин хэрэглэдэггүй» статустай болох өргөдөл гаргах эсэхээ шийднэ. Энэ статусыг авснаар 5-р үе шат буюу ШАХ дуусгавар болно.



Үе шат 1:

- > **ЧИГЛЭЛ:** «Тухайн улсын шүлхий өвчний эпидемиологийн талаар ойлгож, уг өвчний нөлөөг бууруулах зорилгоор эрсдэлд тулгуурласан аргачлал боловсруулна.»
- > **Үе шат 1-т дэвшихэд тавигдах наад захын шаардлага:** Тухайн улсын шүлхий өвчний эпидемиологи, нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөг судалж мэдэх цогц төлөвлөгөө боловсруулсан байх бөгөөд доорх Гол үр дүн 1 ба 2-т чиглэсэн үйл ажиллагаа үр дүнтэй байна.
- > **Гол үр дүн:**
 1. Мал аж ахуйн хэв маяг, зах зээлийн сүлжээ, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлүүд болон шүлхийд мэдрэмтгий мал амьтны уялдааг сайтар тайлбарлаж ойлгоно (нэмүү өртгийн задлан шинжилгээ).
 - *Чанарын шалгуур үзүүлэлт:* Шүлхийд мэдрэмтгий мал амьтныг худалдаж авах, өсгөж үржүүлэх, зах зээлд нийлүүлэх, бүтээгдэхүүн боловсруулж үйлдвэрлэх, хэрэглэх бүхий л шат дамжлагыг тоймлон үзүүлэх ёстой. Ийм мал амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний импорт, отор нүүдэл, бэлчээрийн мал аж ахуйн онцлогтой холбоотой малын хөдөлгөөний асуудлыг мөн адил тайлбарлана. Эдгээр нь байнга өөрчлөгдөж байдаг учир мэдээллийг тогтмол хугацаанд шинэчилнэ.
 - *Нийтлэг үйл ажиллагаа:* Хөдөө орон нутгийн оролцоог дэмжих, оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт-семинар зохион байгуулах, цуглуулсан мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ хийх.
 2. Тухайн орны шүлхий өвчний тархалтыг сайтар судлан ойлгож шүлхийн вирус хэрхэн эргэлдэж байгаа талаарх 'таамаглал' дэвшүүлнэ.
 - *Чанарын шалгуур үзүүлэлт:* Энэ үе шатанд тухайн улсын бүх бүс нутаг, мал аж ахуйн хэв маягийг шүлхийд мэдрэмтгий мал амьтантай холбож авч үзнэ. Шүлхий өвчний нөхцөл байдал хурдан өөрчлөгдөж болох учраас сүүлийн үеийн мэдээлэл цуглуулна (сүүлийн 12 сарын). Мэдээлэлд шүлхий өвчний орон зай, цаг хугацааны болон түр зуурын тархалтын үзүүлэлт, мөн эмнэл зүйн шинж тэмдэгт суурилсан тандалтаас гадна сүрэг/мал аж ахуйн хэв маяг хооронд

-
- эрсдэлийн ялгаа бий эсэхийг тодорхойлох зорилго бүхий² ийлдэс судлалын тандалтыг оруулах нь цаашдын мониторингийн суурь мэдээлэл болно.
- *Нийтлэг үйл ажиллагаа:* Идэвхгүй, идэвхтэй тандалт, мал аж ахуйн харилцан адилгүй хэв маягт шүлхийн тархалтыг тодорхойлох ийлдэс судлалын тандалт, эпидемиологийн оролцоот судалгаа, шаардлагатай тохиолдолд зэрлэг амьтдыг оролцуулан шүлхий өвчин дамжин тархах гол зүйлийг тогтоон эрсдэлийн үнэлгээ хийх.
3. Оролцогч талуудад шүлхий өвчний үзүүлэх нийгэм-эдийн засгийн нөлөөг тооцсон байна.
- *Чанарын үзүүлэлт:* Энэ үе шатанд эдийн засгийн нөлөөллийн бүрэн үнэлгээ хийгдэхгүй. Гэвч шүлхий өвчний улмаас учирч буй хохирол, ялангуяа мал аж ахуйн гол хэв маягт үзүүлж буй шууд нөлөөг тооцох ёстой.
 - *Нийтлэг үйл ажиллагаа:* Хоёрдогч мэдээ мэдээлэлд задлан шинжилгээ хийх, шаардлагатай хүмүүсээс ярилцлага авах, анхдагч мэдээ цуглуулж задлан шинжилгээ хийх.
4. Шүлхийн вирүсийн зонхилон эргэлддэг омгийг тодорхойлсон байна.
- *Чанарын үзүүлэлт:* Дээжийг малын төрөл, газар зүйн бүс нутгуудын төлөөлөл болгож цуглуулна. Шүлхий өвчний нөхцөл байдал байнга өөрчлөгдөж байдаг учраас дээжийг урт хугацааны турш тодорхой давтамжтайгаар цуглуулж шинжилж байх ёстой.
 - *Нийтлэг үйл ажиллагаа:* Дээж цуглуулж үүсгэгчийг лабораторийн аргаар илрүүлэх, тодорхой давтамжтайгаар Олон улсын лавлах лабораторит илгээж вирүсийн шинж чанарыг тодорхойлуулах.

² ШАХ-ний үе шатны Хяналт, Тандалтын Зааварчилгааны дагуу (GCF – Ref: ...)



5. Тэмцэх арга хэмжээний таатай орчинг бүрдүүлэхэд дэвшил гарсан байна.

- *Чанарын үзүүлэлт:* Энэ бол ШАХ-ний **2-р үе шатанд** дэвшихээр төлөвлөж байгаа улсад чухал асуудал. **Нэгдүгээр үе шатанд** шүлхийн тохиолдлыг мэдээлнэ. Гэвч сэжигтэй тохиолдлыг мэдээлэх асуудлыг орхигдуулж болохгүй.
- *Нийтлэг үйл ажиллагаа:* Хөдөө орон нутаг, лабораторийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор шаардлагатай сургалт зохион байгуулах, хөдөө орон нутгийн үйл ажиллагаа, өвчний дэгдэлтийг мэдээлэх, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх мэдээллийн тогтолцоог бий болгох, хууль эрх зүйн орчин нь Мал эмнэлгийн албанаас шүлхийтэй тэмцэх арга хэмжээ хэрэгжүүлэх боломж бүрдүүлсэн эсэхэд үнэлгээ хийх.

6. Тухайн улс бүсийнхээ шүлхий өвчинтэй тэмцэх арга хэмжээнд ил тод, итгэл үнэмшилтэй оролцохоо харуулна.

- *Нийтлэг үйл ажиллагаа:* Өвчин дэгдсэн тохиолдолд ДАЭМБ-д мэдээлэх, ШАХ-ний хүрээнд хэрэгжүүлж буй ажлынхаа үр дүнг бүсийн хэмжээнд танилцуулах (жишээлбэл, бүсийн хурал зөвлөгөөн дээр).

7. Шүлхийн тархалтанд нөлөөлөх гол эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлно.

- *Чанарын шалгуур үзүүлэлт:* Дээрх Гол үр дүн 1, 2-той холбоотой мэдээллийг задлан шинжилгээнд ашиглана. Гол эрсдэлт хүчин зүйлсийг чухлаас нь эхлэн жагсааж, шүлхий өвчин гаднаас орж ирж тархах эрсдэлийг үр дүнтэй бууруулахад ямар мэдлэг дутагдаж байгааг тодорхойлно.
- > *Нийтлэг үйл ажиллагаа:* Шүлхий өвчний эпидемиологи, мал аж ахуйн хэв маягийн талаарх мэдээ мэдээлэлд задлан шинжилгээ хийх, мэдээлэл олдоцтой тохиолдолд шүлхий өвчин гаднаас орж ирж тархахад нөлөөлөх эгзэгтэй асуудлуудыг тодорхойлох зорилгоор эрсдэлийн урьдчилсан үнэлгээ хийх.

> ҮЕ ШАТ 2-Т ДЭВШИХИЙН ТУЛД

8. Наад тал нь нэг бүс эсвэл тодорхой нэг малын төрөлд үзүүлэх шүлхийн сөрөг нөлөөг бууруулах зорилго бүхий Шүлхий өвчинтэй тэмцэх стратеги төлөвлөгөө боловсруулна.

- *Чанарын шалгуур үзүүлэлт:* Тус төлөвлөгөө нь төрийн мал эмнэлгийн эрх бүхий албаар батлагдсан байх ёстой бөгөөд Үе шат 1-ийн бусад үйл ажиллагааны үр дүнд тогтоогдсон эрсдэлд суурилсан байна.
- *Нийтлэг үйл ажиллагаа:* Шүлхий гаднаас орж ирж тархах өндөр эрсдэл бүхий мал аж ахуй, зах зээлийн сүлжээн дэх 'халуун цэгүүд'-ийг тодорхойлно. Эдгээр цэгүүдэд эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөхдөө хэрэгжих боломж, гарах үр нөлөөнд үндэслэнэ. Энэ ажлыг гүйцэтгэхэд эрсдэлийн үнэлгээний арга, ялангуяа эрсдэлийн замналыг тодорхойлох нь ач холбогдолтой.
- Энэ нь **Үе шат 2-т** дэвших улсад шаардлагатай.

Үе шат 2:

> **ЧИГЛЭЛ:** «Нэг болон хэд хэдэн малын төрөл/нэг болон хэд хэдэн бүсэд шүлхий өвчний нөлөөг бууруулах зорилгоор эрсдэлд суурилсан тэмцэх арга хэмжээ хэрэгжүүлнэ.»

> **Үе шат 2-т дэвшихэд тавигдах наад талын шаардлага:** Өмнөх Үе шатыг дуусгасан байх бөгөөддоорх Гол Үр дүн 1 ба 2-т чиглэсэн үйл ажиллагаа үр дүнтэй байна.

> **Гол үр дүн:**

1. Эргэлдэж буй вирусийн омгийг тандах, мал аж ахуйн өөр өөр хэв маягт үзүүлж буй эрсдэлийг судлах ажил үргэлжилсээр байна.

- *Чанарын шалгуур үзүүлэлт:* Тухайн улс **Үе шат 1-т** заасан үйл ажиллагааг үргэлжлүүлж, мэдээ мэдээлэл, түүнд хийх задлан шинжилгээг цаг үетэй нь нийцүүлэн шинэчилж байх хэрэгтэй. Түүнчлэн эгзэгтэй чухал зүйлүүдийг буруу зөрүү ойлгосон бол олж тогтоон, засаж залруулж байхаас гадна нэн ялангуяа



-
- тэмцэх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэгийг олж авахад анхаарна. Ингэж чадвал шүлхийн эпидемиологийн талаар илүү ойлгож, эрсдэлийг бууруулах боломжит хувилбарыг сонгоход хялбар болох болно.
- *Нийтлэг үйл ажиллагаа: Үе шат 1-ийн* үйл ажиллагааг үргэлжлүүлнэ. Нэмж, мэдлэгийн цоорхойг нөхөхийн тулд зорилтот судалгааны ажил зохион байгуулах (жишээлбэл, ийлдэс судлалын зорилтот тандалт, идэвхтэй тандалт, эпидемиологийн оролцоот судалгаа, эрсдэлийн үнэлгээ гэх мэт); сэрэмж дээшлүүлэх, мэдээлэл солилцох .
2. **Үе шат 1-т** боловсруулсан Шүлхий өвчинтэй тэмцэх стратеги төлөвлөгөөнд үндэслэн эрсдэлд суурилсан тэмцэх арга хэмжээг зорилтот малын төрөл эсвэл бүсэд хэрэгжүүлнэ.
- *Чанарын шалгуур үзүүлэлт:* Тэмцэх арга хэмжээг эгзэгтэй эрсдэлт цэгүүдэд чиглүүлэх ёстой. Үүнд вакцинжуулалт болон био-аюулгүй ажиллагааг хангах ажлууд орно.
 - *Нийтлэг үйл ажиллагаа:* Вакцин түгээх механизм, хүйтэн хэлхээг сайжруулах, худалдааны газраар дамжин шүлхий тархах асуудлыг бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэх, шүлхийн халдварлалтын механизмын талаар сэрэмжийг дээшлүүлж, халдварлалтыг таслан зогсоох зан үйлд хэвшүүлэх, хилийн хяналт, хөдөлгөөний хяналтыг сайжруулах, био-аюулгүй ажиллагааг хангах, мал аж ахуй болоод зах зээлийн сүлжээний бүхий л шат дамжлагын чухал цэгүүдэд эрүүл ахуйн дэглэмийг сахиж, цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг тогтмол хугацаанд хийж занших (малын шилжилт хөдөлгөөнтэй болон худалдааны газар).
3. Тэмцэх арга хэмжээний үр дүнд малын зарим төрөл/бүсүүдэд шүлхий өвчний үзүүлэх нөлөө буурч байгаа нь ажиглагдана.
- *Чанарын шалгуур үзүүлэлт:* Тэмцэх арга хэмжээ зүй зохистой хэрэгжиж хүссэн үр дүнд хүрч байгааг харуулах нь чухал.
 - *Нийтлэг үйл ажиллагаа:* Вакцинжуулалтын арга хэмжээнд зорилтот бүлэг хэрхамарсныг тодорхойлох зорилгоор ийлдэс судлалын тандалт зохион байгуулах, вакцины тохирлыг лабораторийн шинжилгээгээр нотлох, зорилтот бүлэгт шүлхийн тархалт урт хугацааны туршид хэрхэн өөрчлөгдөж байгааг

судлах зорилгоор тандалтын мэдээнд задлан шинжилгээ хийх, тэмцэх арга хэмжээнд үнэлгээ хийх (зардлын үр ашиг, хэрэгжилтийн хувь, нөлөө), тодорхой дэгдэлтүүдийг сонгож судлах (тэмцэх арга хэмжээ хэрэгжүүлсэн нутагт гарсан дэгдэлтийг оролцуулна), био-аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангаж байгаа эсэхийг баримтжуулан шалгах.

4. Тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх орчныг бүрдүүлэх талаар ажилласаар байна.

- *Чанарын шалгуур үзүүлэлт:* Тэмцэх арга хэмжээ, тандалт шинжилгээг зохион байгуулах ажил хууль эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн байх, мөн тухайн улс тэмцэх арга хэмжээний үр дүнтэй, тогтвортой хөтөлбөрийг боловсруулахад итгэлтэй байгааг нотлох шаардлагатай.
- *Нийтлэг үйл ажиллагаа:* **Үе шат 1-ийн** үйл ажиллагааг үргэлжлүүлнэ. Нэмж, мал эмнэлгийн албаны хууль эрх зүйн орчин, үйл ажиллагааны чадавхийг үнэлж, вакцинжуулалт, халдварын дэгдэлтийг судлах зэрэг үйл ажиллагааг саадгүй явуулахад шаардлагатай засвар өөрчлөлт хийх (жишээлбэл, аж ахуйд нэвтрэх, малд үзлэг хийх, дээж авах, малчнаас асуумж авахэртэй байх), төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаан дээр тулгуурлан вакцинжуулалтын арга хэмжээг зохион байгуулж төрөлжүүлэх, задлан шинжилгээ, зураглал хийхэд зориулж газар зүйн заалттай мэдээллийн тогтолцоо нэвтрүүлэх, малын хөдөлгөөн, худалдааны газраар дамжин өвчин тархах эрсдэлийг бууруулах зорилгоор шаардлагатай зохицуулалтыг санаачилж хэрэгжүүлэх (жишээлбэл, худалдааны газар, тээврийн хэрэгслийн зохицуулалт).

> ҮЕ ШАТ 3-Т ДЭВШИХИЙН ТУЛД

5. Тухайн улсын дор хаяж нэг бүсэд шүлхий өвчнийг устгах зорилго бүхий сайтар хянасан, илүү эрчтэй стратеги төлөвлөгөө боловсруулсан байна.

- *Чанарын шалгуур үзүүлэлт:* Тус төлөвлөгөө төрийн мал эмнэлгийн эрх бүхий албаар батлагдсан байх ёстой. Төлөвлөгөөнд халдварын тархалтыг хязгаарлахын тулд цаг алдалгүй илрүүлж, шуурхай хариу арга хэмжээ авах заалт оруулна.
- *Нийтлэг үйл ажиллагаа:* Үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах болон шуурхай хариу арга хэмжээ авах бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулна.



Үе шат 2-т хэрэгжүүлсэн тэмцэх стратегийг бодвол энэ стратеги илүү эрчтэй. Төлөвлөгөө нь өвчин хэзээ ч, хаана ч илэрсэн гэсэн шуурхай илрүүлж, халдварын тархалтыг хязгаарлах хариу арга хэмжээ авах чадвартай байна. Малын нэг төрөл эсвэл бүсэд зориулж тэмцэх арга хэмжээ хэрэгжүүлж байсныг бодвол улсын юм уу бүсийн хэмжээнд бүх мэдрэмтгий малаас шүлхийг устгахад анхаарал хандуулна.

- Энэ нь **Үе шат 3-т** дэвших улс/бүсэд шаардлагатай.

Үе шат 3:

- > **ЧИГЛЭЛ:** «Тухайн улсын дор хаяж нэг бүсэд шүлхий дэгдэх явдлыг аажим багасгаж, улмаар мал сүрэгт эргэлдэж буй шүлхийн вирүсийг устгана.»
- > **Үе шат 3-т дэвшихэд тавигдах минимум шаардлага:** Өмнөх Үе шатыг дуусгасан байх бөгөөд доорх Гол Үр дүн 1 ба 2-т чиглэсэн үйл ажиллагаа үр дүнтэй байна.
- > **Гол үр дүн:**
 1. Эргэлдэж буй вирүсийн омгийг тандах, мал аж ахуйн өөр өөр хэв маягт үзүүлж буй эрсдэлийг судлах ажил үргэлжилсээр байна.
 - *Чанарын шалгуур үзүүлэлт:* Тэмцэх арга хэмжээний боломжит хувилбаруудыг үр дүнтэй ашиглан шүлхий өвчний малд үзүүлэх нөлөөг аажим устгах зорилгоор эрсдэлийн хүчин зүйлийн талаарх бүхий л мэдлэгийг ашиглана.
 - *Нийтлэг үйл ажиллагаа:* Тухайн улс Үе шат 1, 2-т заасан үйл ажиллагааг үргэлжлүүлсээр байх бөгөөд тэмцэх арга хэмжээ бодитой, үр дүнтэй байгаа эсэхийг судлахын тулд цуглуулсан мэдээнд задлан шинжилгээ хийж байх ёстой. Хэрэв тэмцэх арга хэмжээ тооцоолж байсан шиг үр дүнтэй биш байгаа нь харагдвал өөрчилж сайжруулна.
 2. **Үе шат 2-ын** төгсгөлд боловсруулсан тэмцэх төлөвлөгөөг хэрэгжүүлснээр тухайн орны дор хаяж нэг бүсэд бүх халдварыг шуурхай илрүүлж хариу арга хэмжээ авна.
 - *Чанарын шалгуур үзүүлэлт:* **Үе шат 2-т** хэрэгжүүлж байсан тэмцэх стратегитай харьцуулахад энэ стратеги илүү эрчтэй бөгөөд малын гол төрөл(үүд)-д

-
- төвлөрч байсан анхаарлаа тухайн улс юм уу бүсийн бүхий л мэдрэмтгий малд шилжүүлнэ. Энэ үе шатанд Шүлхий өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрөө албан ёсоор батлуулахаар ДАЭМБ-д хандаж болно.
- *Нийтлэг үйл ажиллагаа: Үе шат 2-ын* үйл ажиллагааг үргэлжлүүлнэ. Нэмж, өвчнийг мэдээлэх, хариу арга хэмжээ авахад анхаарна (жишээлбэл, олон нийтийн сэрэмжийг дээшлүүлэх кампанит ажил зохион байгуулах, мэдээлэл өгсөн хүнийг урамшуулах, үнэгүй утас ажиллуулах гэх мэт). Шүлхий өвчин дэгдэх болгонд хариу арга хэмжээ авч, вирусийн тархалтыг хязгаарлана (жишээлбэл, халдвартай сүргийг устгах, хөдөлгөөнд хяналт тавих, хөдөлгөөнийг хязгаарлах, бүслэх эсвэл хаалт тавих зэрэг тактикийн шинж чанартай вакцинжуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх). Халдвар дэгдэх болгонд эпидемиологийн бүрэн судалгаа хийж эх үүсвэр, тархалт (орон зай-цаг хугацааны, түр зуурын)-ын талаар тайлагнах бөгөөд өвчний тархалт ямар механизмаар явагдсан байж болох тухай дүгнэлт гаргана.
3. Тухайн улсын дор хаяж нэг бүсэд мал эмнэл зүйн шинж тэмдэгтэй өвчлөх явдал аажим устана.
- *Чанарын шалгуур үзүүлэлт:* Шүлхийн вирус малаас аажим арилж байгаа, тэмцэх арга хэмжээний үр дүнд зэрлэг амьтад болон гадны орнуудаас шүлхий орж ирэх/тархах эрсдэл буурч байгаа нь эпидемиологийн үнэмшилтэй нотлогдсон байна.
 - *Нийтлэг үйл ажиллагаа:* Ийлдэс судлалын шинжилгээг оролцуулан идэвхтэй, идэвхгүй тандалтаар цуглуулсан тоо мэдээнд задлан шинжилгээ хийх.
4. Тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх орчныг сайжруулсаар байна.
- *Үйл ажиллагаа:* Үе шат 1, 2-ын үйл ажиллагааг үргэлжлүүлнэ. Нэмж, халдварын дэгдэлтийг тархахаас сэргийлэх зорилгоор малын хөдөлгөөнийг хязгаарлах хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Шүлхийн сэжигтэй тохиолдлыг мэдээлэх ажлыг оролцогч бүх талууд дэмжинэ. Шаардлагатай хариу арга хэмжээний хүрээнд мал устгах, түүний нөхөн олговор/даатгалыг зохион байгуулах ажлыг зохицуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.



Санамж: Дөрөвдүгээр хуудсанд тайлбарласны дагуу ШАХ-ний **3-р үе шатанд** орсон улс цаашид 4 болон түүнээс дээш үе шатанд дэвшихээр шийдвэр гаргах нь мал сүргээс шүлхийн вирүсийн халдварыг арилгах зорилт тавьсныг илтгэх бөгөөд энэ тохиолдолд Шүлхий өвчнийг устгах үндэсний хөтөлбөрөө баталгаажуулахаар ДАЭМБ-д хандаж болно. Баталгаажуулах журмыг ДАЭМБ-аас авна. Энэ үе шатанд тухайн улсын Мал эмнэлгийн албаны үйл ажиллагааг үнэлсэн сүүлийн үеийн дүгнэлт шаардагдаж болзошгүй.

> ҮЕ ШАТ 4-Т ДЭВШИХИЙН ТУЛД

5. Тухайн улс эсвэл бүсийн мал сүрэгт шүлхийн вирүсийн байнгын эргэлт байхгүйг нотолно.
 - *Чанарын шалгуур үзүүлэлт:* Бүхий л бүс, мал аж ахуйн хэв маягийг хамруулан өндөр чанартай шүлхийн тандалт зохион байгуулдаг болохоо нотолно. Тандалтын үйл ажиллагаа нь шүлхийн халдвар гарсан тохиолдолд илрүүлэх чадавхтай байна (жишээлбэл, ДАЭМБ-ын Хуурай газрын амьтны эрүүл мэндийн кодоод заасан тандалтын стандартад нийцсэн). Гадаад орон болон зэрлэг амьтдаар дамжин хаа нэг орж ирдэг халдварыг эс тооцвол шүлхийн тохиолдол тэг хүртэл буурсан байна. Гаднаас болон зэрлэг амьтдаар дамжин орж ирсэн бүх дэгдэлтийг мөрдөн судалж, богино хугацаанд устгаж чаддаг байна. Вакцинжуулалтын хөтөлбөр болон дархлаажилтын түвшинд хийх хяналтыг амжилттай зохион байгуулна.
 - *Нийтлэг үйл ажиллагаа:* Вирүс судлалын шинжилгээний дүн, халдварын эх уурхай гэх мэтчилэн дэгдэлтийн судалгааны мэдээлэл, ийлдэс судлалын тандалтын мэдээнд задлан шинжилгээ хийх.
 - Энэ нь **Үе шат 4-т** дэвшихэд шаардлагатай.

Үе шат 4:

- > **ЧИГЛЭЛ:** «Улс/бүсийн хэмжээнд ‘шүлхийн халдваргүй’ байдлаа хадгалж, улмаар ‘шүлхийгүй-вакцин хэрэглэдэг’ статусыг ДАЭМБ-аар баталгаажуулна.»
- > **Үе шат 4-т дэвшихэд тавигдах наад талын шаардлага:** Өмнөх Үе шатыг дуусгасан байх бөгөөддоорх Гол Үр дүн 1 ба 2-т чиглэсэн үйл ажиллагаа үр дүнтэй байна.
- > **Гол үр дүн:**
 1. Мал аж ахуйн өөр өөр хэв маягуудыг хамруулан шүлхийн тандалт, эрсдэлийн судалгааг үргэлжлүүлэн зохион байгуулна.
 - *Чанарын шалгуур үзүүлэлт:* Тэмцэх арга хэмжээний боломжит хувилбаруудыг үр дүнтэй ашиглан шүлхий өвчнийг бууруулах зорилгоор эрсдэлийн хүчин зүйлийн талаарх бүхий л мэдлэгийг ашиглана.
 - *Нийтлэг үйл ажиллагаа:* Өмнөх үе шатуудад явуулж байсан үйл ажиллагаагаа үргэлжлүүлсээр байх ёстой.
 2. «Шүлхийгүй-вакцин хэрэглэдэг» статусыг ДАЭМБ-аар албан ёсоор баталгаажуулахад тавигддаг шаардлагыг биелүүлэх төлөвлөгөө боловсруулна.
 - *Чанарын шалгуур үзүүлэлт:* Тус төлөвлөгөө нь ДАЭМБ-ын Хуурай газрын амьтны эрүүл мэндийн кодоод заасан шаардлагуудыг тусгасан байна.
 3. Тухайн улс/бүсэд шүлхий орж ирэх эрсдэлийг бууруулна.
 - *Чанарын шалгуур үзүүлэлт:* Хилийн аюулгүй байдалд тавих анхаарал нэмэгдсэн гэдгийг нотолно.
 - *Нийтлэг үйл ажиллагаа:* Хилийн хяналтыг чангатгах, мэдрэмтгий зэрлэг амьтад болон малын хооронд шүлхийн халдвар дамжихаас сэргийлэх зорилго бүхий эрсдэлийг бууруулах арга хэмжээг сайжруулах.
 4. Шүлхийн тохиолдол маш цөөн, гаднаас хаа нэг орж ирдэг төдийгөөр хязгаарлагддаг («шүлхийгүй-вакцин хэрэглэдэг» статус авахад энэ халдварыг зогсоосон байх ёстой).



-
- *Чанарын шалгуур үзүүлэлт:* Шүлхийн тохиолдол маш цөөн, мал сүрэгт вирусийн байнга эргэлт үгүй гэдгийг эпидемиологийн хувьд үнэмшилтэй нотолно.
 - Нийтлэг үйл ажиллагаа: Идэвхтэй, идэвхгүй, ийлдэс судлалын тандалт хийх, дэгдэлтийг нягт судлах

5. Тэмцэх арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх орчныг бүрдүүлнэ.

> **Үе шат 5-д дэвшихийн тулд**

6. ДАЭМБ-аар «Шүлхийгүй-вакцин хэрэглэдэг» статусыг баталгаажуулахад тавигддаг шаардлагыг биелүүлж, холбогдох бичиг баримтыг ДАЭМБ-д хүргүүлнэ.

- *Үйл ажиллагаа:* ДАЭМБ-ын кодод заасан хугацааны турш өвчний тохиолдол илрээгүйг батлах үр дүнтэй тандалт зохион байгуулна.
- Энэ нь **Үе шат 5-д** дэвшихэд шаардлагатай.

Үе шат 5:

> **ЧИГЛЭЛ:** «Улс/бүсийн хэмжээнд ‘шүлхийн шинэ тохиолдол илрээгүй’ байдлаа хадгалж, улмаар ‘шүлхийгүй-вакцин хэрэглэдэггүй’ статусыг ДАЭМБ-аар баталгаажуулна.»

> **Үе шат 5-д дэвшихэд тавигдах наад талын шаардлага:** Өмнөх Үе шатыг дуусгаж, ДАЭМБ-аар «шүлхийгүй-вакцин хэрэглэдэг» статусаа баталгаажуулсан байна.

> **Гол үр дүн:**

1. Малд шүлхийн дэгдэлт гараагүй байдлаа хадгална.

- *Чанарын шалгуур үзүүлэлт:* Шүлхийн халдвар байхгүй, өвчин дэгдсэн тохиолдолд илрүүлнэ гэсэн үнэмшилтэй нотолгоо шаардлагатай (жишээлбэл, мал эмнэлгийн албаны чадвар, тандалтын хөтөлбөр амжилттай хэрэгждэг, сэжигтэй тохиолдлыг нуулгүй мэдээлдэг).

-
- *Нийтлэг үйл ажиллагаа:* Идэвхтэй, идэвхгүй, ийлдэс судлалын тандалт зохион байгуулах, сэжигтэй тохиолдол илэрсэн тухай мэдээлэл авмагц шуурхай, нягт судалж шинжлэх.

ҮЕ ШАТ 5 БУЮУ ШАХ-Г ДУУСГАВАР БОЛГОХЫН ТУЛД

2. ДАЭМБ-аас «Шүлхийгүй-вакцин хэрэглэдэггүй» статусыг авахад тавигддаг шаардлагыг биелүүлж, холбогдох бичиг баримтыг ДАЭМБ-д хүргүүлнэ.
 - *Үйл ажиллагаа:* ДАЭМБ-ын кодод заасан хугацааны турш өвчний тохиолдол илрээгүйг батлах үр дүнтэй тандалт зохион байгуулна.
 - Энэ нь **Үе шат 5** буюу ШАХ-г дуусгавар болгоход шаардлагатай.



ТЭМДЭГЛЭЛ

